



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 443

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэний Нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 56,905,000.00 (тавин зургаан сая есөн зуун таван мянган) төгрөгийн балансын үнэ, 9,484,166.68 (есөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Улсын ерөнхий прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Иргэний Нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Улсын Ерөнхий Прокурорын газрын улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР


Б.ГАВАА



0002315



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 10 дугаар сарын 18 ны өдрийн  
 443 дугаар тогтоолын харсралт



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАРТ  
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (дм)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
1	Ниссан Теанна, 01-83 УБИ, 1N4AL3AP9GC18162, Суудлын автомашин	2016/2017	1593	56,905,000.00	9,484,166.68	47,420,833.32
<b>НИЙТ ДҮН</b>						
				<b>56,905,000.00</b>	<b>9,484,166.68</b>	<b>47,420,833.32</b>
				(тавин зургаан сая есөн зуун таван мянган)	(есөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран найман мөнгө)	(дөчин долоон сая дөрвөн зуун хорин мянга найман зуун гучин гурван төгрөг гучин хоёр мөнгө)